

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

АГУУЛГА

Нэг. Удиртгал.....	2
Хоёр. Макро эдийн засгийн өнөөгийн төлөв байдал, эрсдэл.....	2
Гурав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хоорондын уялдаа, хамаарал, залгамж чанар.....	3
Дөрөв. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл ба жилийн төлөвлөгөөний уялдаа.....	6
Тав. Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүн ба хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт хоорондын уялдаа, нийцэл.....	8
Зургаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний санхүүжилт, түүний эх үүсвэр.....	9
Долоо. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан мега төслүүдийн талаар.....	12
Найм. Дүгнэлт, зөвлөмж.....	15
Хавсралтууд.....	17

НЭГ. УДИРТГАЛ

Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах” тухай УИХ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтын дагуу уг төсөл нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаж буй байдлыг болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.13, 6.10.1, 6.10.2 дахь заалтад тусгасан шаардлагад нийцсэн эсэхийг шинжилж, дүгнэлтээ боловсруулав.

ТТБЗ дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэл болголоо.

УИХ-д Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” (Хавсралт 1), “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө” (Хавсралт 2), “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” (Хавсралт 3) гэсэн баримт бичгүүдийг судалж, макро эдийн засгийн 2026 оны төлөв байдал, эрсдэл, бодлогын уялдаа, стратегийн нийцэл, хуулийн нийцэл, бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө, хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, төсөв хоорондын уялдааг SMART үнэлгээ, нийцлийн шинжилгээний аргачлалыг ашиглан шинжилсэн болно.

ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРСДЭЛ

Эдийн засгийн нөхцөл байдал таагүй болж байна. Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд түүхий эдийн үнэ, гадаад зах зээлийн эрэлтээс шууд хамаарал бүхий уул уурхайн салбарын тогтворгүй байдлаас шалтгаалан хэлбэлзэлтэй өсөлттэй явж ирсэн. Харин 2023 оноос эдийн засагт сэргэлт ажиглагдаж, ДНБ-ий өсөлт 2023 онд 7.0, 2024 онд 4.9 хувь болсны зэрэгцээ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өмнөх онуудтай харьцуулахад сайжирсан ч 2024 оны эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас 2.1 нэгж хувиар доогуур гарсан. Энэ нь цар тахлын дараа эрдэс баялаг, түүний дотор нүүрсний салбараас хамаарсан өсөлтийн үе өнгөрч байгааг анхааруулсан дохио төдийгүй мөчлөг дагасан ихээхэн тэлэлттэй төсвийн бодлого баримталж буй өнөө үед анхаарах асуудал гэдэг нь тодорхой. Эдийн засгийн өсөлтөд эрдсийн түүхий эдийн экспорт, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хэрэглээ, бизнесийн орчин голлон нөлөөлж байгаа юм. *ТТБЗ-өөс урьд нь сануулж байсан “эдийн засгийн таатай нөхцөл байдал хэвээр хадгалагдана гэж төсөөлөх, найдах хэрэггүй” гэсэн дүгнэлт өнөөдөр “нөхцөл байдал хэдийн тааламжгүй болж эхлээд байна” (Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, 2025) гэж өөрчлөгдөж байна.*

Монгол Улсын эдийн засагт гадаад, дотоод орчны эрсдэл учрах магадлал өндөр байна. Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эрчим хүчний хангамж хүрэлцэхгүй байх, сүүлийн үед давтамж нь нэмэгдэх болсон ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт, гадаад орчны тааламжгүй,

тодорхойгүй байдал, зээлжих зэрэглэл буурах зэрэг олон эрсдэл манай улсын эдийн засагт учирч болзошгүй байна. Түүнчлэн ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнээс орлогын хэт хамааралтай байдал, өрийн дарамт нэмэгдэж байгаа, төсвийн алдагдал өндөр, макро эдийн засгийн тогтворгүй байдал, төсвийн зардал хэт өндөр, сахилга бат сул зэрэг хүчин зүйлсийг дурдаж болно. Ийнхүү гадаад, дотоод эрсдэл өндөр байгаа нь Монгол Улсын эдийн засгийг хүндрэл, хямралд хүргэхгүй, геоэдийн засаг, геополитикийн тодорхойгүй байдал, сорилтыг даван туулах бэлтгэлтэй байж, Засгийн газар хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах шаардлага тулгарч байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХООРОНДЫН УЯЛДАА, ХАМААРАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР

Аливаа улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь төсөв, санхүүгийн нөөцийг хуваарилах асуудалтай нягт уялдаатай төдийгүй урт хугацааны хөгжлийн стратеги төлөвлөлт нь дунд хугацааны хөгжлийн бодлого болон жилийн хөгжлийн төлөвлөгөөг дотроо агуулдаг. Манай улсын хувьд урт хугацааны хөгжлийн бодлого нь “Алсын хараа-2050”, харин дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны дөрвөн жилийн хөтөлбөр, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсвөөс бүрдэж байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд нийцүүлэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрийн “бодлогын үндэслэл”-ийг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсруулсан байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж буйг үнэлж, дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө ба урт, дунд хугацааны бодлогын уялдаа

№	Баримт бичиг	Уялдаа	Тайлбар
1	Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”	⚠ Зарчмын түвшинд уялдсан	Хөгжлийн 9 зорилгоос 6–7 нь жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан боловч суурь үзүүлэлт, үе шат, шалгуур нь тодорхойгүй
2	Шинэ сэргэлтийн бодлого	✓ Сайн уялдсан	Шинэ сэргэлтийн бодлогын 6 чиглэл (эрчим хүч, төрийн бүтээмж, аж үйлдвэржилт гэх мэт) шууд тусгагдсан
3	Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG)	⚠ Зорилгын хувьд уялдсан, шалгуур үзүүлэлтийн тухайд сул	Хүний хөгжил, ядуурал, боловсрол, эрүүл мэнд, жендер, дэд бүтэц зэрэг зорилгууд тусгагдсан ч ТХЗ-ын үзүүлэлтүүдийг шууд ашиглаагүй
4	Бүсчилсэн хөгжил, салбарын бодлого	⚠ Хэсэгчлэн уялдсан	Бүсчилсэн хөгжлийн агуулга сайн тусгагдсан ч зарим салбарын бодлогын баримт бичигтэй нарийн уялдаагүй (тухайлбал Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөө гэх мэт) байна
5	Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	✓ Сайн нийцсэн	ЗГҮАХ-ийн зорилго, хөтөлбөр, мега төсөл, реформууд жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан

Эх сурвалж: Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд үндэслэн ТТБЗ-өөс өгсөн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой **зорилгын хувьд уялдаатай** боловч **гүйцэтгэлийн түвшинд** (шалгуур үзүүлэлт, мониторинг) **уялдаа нь бүрэн хангагдаагүй** байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хуульд тусгагдсан шаардлагуудыг Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө хангаж байгаа эсэхийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх

№	Хуулийн шаардлага	2026 оны төлөвлөгөөний байдал	Үнэлгээ
1	Бодлогын зорилго, зорилт тодорхой байх	Бодлогын тэргүүлэх 4 үндсэн чиглэл (эдийн засаг, хүний хөгжил, бүсчилсэн хөгжил, засаглал) ба дэд зорилтууд тодорхой тусгагдсан	✓ Сайн
2	Үр дүнд суурилан төлөвлөсөн байх	Хавсралт 2-т зарим шалгуур үзүүлэлт нь тодорхой, гэхдээ SMART биш үзүүлэлт олон	⚠ Дунд
3	Төрийн байгууллагын оролцоо, хариуцлага тодорхой байх	Хариуцагч байгууллагуудыг заасан ч хяналт шинжилгээ, хариуцлагын механизм тодорхойгүй	⚠ Дунд
4	Төлөвлөгөөний уялдаа, давхардалгүй байдал	Бодлогын 3 баримт бичиг (хавсралтууд)-ийн хоорондын үндсэн уялдаа сайн	✓ Сайн
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо тусгагдсан байх	Үзүүлэлтүүдийн үнэлгээ, тайлагналын хугацаа, аргачлал тусгагдаагүй	✗ Хангалтгүй

Эх сурвалж: Хууль тогтоомжид үндэслэн ТТБЗ-ийн хийсэн үнэлгээ

Жилийн хөгжлийн төлөвлөгөө нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан **бодлого, төлөвлөлтийн бүтэц, шатлал, логик уялдааг хангаж байгаа** боловч **хяналт шинжилгээ, гүйцэтгэлийн хариуцлага, шалгуур үзүүлэлтүүд SMART байх шаардлагыг дутуу хангасан** байна.

Хүснэгт 3. Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх

№	Хуулийн шаардлага	2026 оны төлөвлөгөөний байдал	Үнэлгээ
1	Төсөв нь хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байх	Үйл ажиллагаанд зориулах хөрөнгийг (Хавсралт 2) тусгасан, гэхдээ зарим төсөл, хөтөлбөрийн зардал, санхүүжилт, зорилтот үр дүн нь тодорхойгүй	⚠ Хэсэгчлэн хангасан
2	Хөрөнгө оруулалтын зардлын үндэслэл тодорхой байх	Томоохон төслүүдийн зардал, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөж, үр ашиг тусгагдаагүй	✗ Хангалтгүй
3	Төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдалтай уялдуулах	Өрийн үйлчилгээ, төсвийн тэлэлттэй холбоотой үр нөлөө тусгагдаагүй	⚠ Дунд
4	Зардлын бүтэц үр ашигтай, үр дүнтэй байх	Зарим хөрөнгө оруулалттай дүйцэхүйц үр дүнгийн шалгуур дутуу	⚠ Дунд
5	Төсвийн хуваарилалт нь бодит хэрэгцээнд суурилсан байх	Зарим салбарт хэрэгжих ажил бодлогын хувьд чухал боловч санхүүжилт тодорхойгүй (жишээлбэл, цахим засаглал, төрийн албаны шинэчлэл)	⚠ Хязгаарлагдмал

Эх сурвалж: Хууль тогтоомжид үндэслэн ТТБЗ-ийн хийсэн үнэлгээ

Жилийн хөгжлийн төлөвлөгөө нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг **ерөнхий түвшинд хангасан** боловч **хөрөнгө оруулалтын үндэслэл, нэгж төслийн үр ашгийн тооцоо, үр дүн, зардал-үр дүнгийн хамаарал сул** буюу төсвийг тооцож төлөвлөгөөнд тусгахдаа шалгуур үзүүлэлт нь үр дүнтэй шууд холбоотой байх зарчмыг баримтлаагүй байна.

Мөн уг төлөвлөгөө нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан *зохион байгуулалт, логик уялдаа, бодлогын шатлалтай холбогдох шаардлагыг харьцангуй сайн хангасан* хэдий ч Төсвийн тухай хуулийн *хөрөнгө оруулалтын үр ашгийн үндэслэл, хяналт-шинжилгээний тогтолцоо, үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй холбоотой шаардлагыг бүрэн хангаагүй* байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд тухайлбал, “Алсын хараа 2050”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2026-2028 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний дотор *төсвийн зарлагын хоорондын уялдаа, хамаарлыг авч үзвэл нэлээд учир дутагдалтай байна.*

Засгийн газраас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд төсвийн зарлагыг 30.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 31.7 хувь байхаар УИХ-д өргөн мэдүүлсэн. Түүнчлэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлээр улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33.5 их наяд төгрөгт буюу ДНБ-ий 31.7 хувьд хүрэхээр байна. Бодит байдалд экспортын болон төсвийн гүйцэтгэл төсөөлж буй хэмжээнээс буурах, төсвийн орлого тасалдах, улмаар улсын төсвийн алдагдал нэмэгдэх, 2026 оны улсын хөгжлийн болон төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан ч орлого, санхүүжилтийн тасалдлын улмаас *хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилга объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх магадлал өндөр байна.* Иймд Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг *бүхэлд нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал* гэж үзэж болохоор байна.

“Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль нь Үндсэн хуулийн “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх” зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд 25 дугаар зүйлийн 25.1.7-д заасан “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” харилцааг зохицуулдаг. Түүнчлэн тус хуульд *урт хугацааны хөгжлийн бодлого нь зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс, харин дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээс бүрдэхээр* тогтоосон.

Энэхүү хуулийн 6.7, 6.8, 6.9, 6.10-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг *нэн тодорхой, харилцан уялдаатай боловсруулж баталсан байх*, тэдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтууд, төсөл, хөтөлбөрийг *хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийн тооцооллыг урьдчилан хийсэн байхыг* шаарддаг. Ингэснээр чухам ямар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэдэн онд, ямар хэмжээний хөрөнгө шаардлагатай, энэ эх үүсвэрийг нийт эдийн засагт дарамт учруулахгүй, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүйгээр бүрдүүлэх боломжтойг тодорхойлсноор макро эдийн засгийн зохистой байдал, тэнцлийг хангахуйц хөгжлийн бодлого боловсруулах нөхцөл бүрдэх юм. *Гэвч төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, мониторинг, тайлагналын аль ч шатанд доголдол гарч байна.*

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БА ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УЯЛДАА

Монгол Улсын хөгжлийн 2026 оны бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн төлөвлөгөөний төлөвлөгөөний зорилго, зорилт: “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 4.1.13-т заасны дагуу “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” нь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг” юм. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хавсаргасан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн **дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд бодлогын 20 зорилгод хамаарах 106 зорилтыг дэвшүүлсэн** байна (Хавсралт 1). Түүнчлэн 2026 онд баримтлах бодлогоо **“Хүн төвтэй”** хөгжлийн үзэл санаанд нийцсэн **“Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох”** гэж томъёолон ядуурлыг бууруулахад чиглэсэн төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө нь дараах **ололттой талуудыг** агуулж байна. Үүнд:

- **Стратегийн уялдаа сайтай:** Төрийн бодлогын бүх түвшний баримт бичгүүдтэй зорилго, чиглэл, арга хэмжээний хувьд уялдаа нь хангагдсан.
- **Салбар дамнасан реформ хийхийг зорьсон:** Эдийн засаг, төрийн алба, төсвийн зардал, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компаниудын засаглал, боловсрол зэрэг салбарт томоохон реформ хийхээр төлөвлөсөн.
- **Технологи суурилсан хөгжлийн чиг хандлагыг баримталж байгаа:** Хиймэл оюун, өндөр технологи, инновацид суурилсан эдийн засаг, боловсролын бодлогыг хэрэгжүүлэх ажил тодорхой тусгагдсан.
- **Бүсчилсэн хөгжлийн бодлогыг нарийвчилсан:** Бүсийн онцлог, кластер хөгжүүлэлт, логистик, үйлдвэрлэлийн бүс, хөрөнгө оруулалтын уялдаатай бодлогыг тусгасан.
- **Ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:** Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, орон сууц зэрэг чиглэлээр бодитой арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь бодлогын тэргүүлэх чиглэлийн зорилгуудыг хэрэгжүүлэх төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн үр дүн, зорилт, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцагч байгууллага зэргийг багтаасан нарийвчилсан төлөвлөгөө юм. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа **бодлогын 20 зорилго, 106 зорилтыг хэрэгжүүлснээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд 63 үр дүн, хөтөлбөрийн 81 үр дүнд хүрэхээр тооцсон** байна.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан олон үйл ажиллагаа **бодлогын тэргүүлэх чиглэлийн зорилгуудтай уялдсан** байна. Тухайлбал, Боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгод хүрэхийн тулд сургууль, эмнэлэг шинээр барих, багш, эмчийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа тусгагдсан байна. Мөн Эдийн засгийн төрөлжилтийн хүрээнд кластер хөгжүүлэх, технологийн парк байгуулах, экспорт дэмжих арга хэмжээнүүд оржээ.

Бодлогын тэргүүлэх чиглэл ба жилийн хөгжлийн төлөвлөгөөг харилцан уялдаатай боловсруулсан ч нийцэл нь бүрэн хангагдаагүй байна. Жилийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг баримтлахаар (УИХ-ын тогтоолын төслийн 1-р хавсралт) боловсруулсан нь сайшаалтай. Гэвч “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө” (УИХ-ын тогтоолын төслийн 2-р хавсралт)-нд эдгээр тэргүүлэх чиглэлийн зарим зорилтыг огт тусгаагүй, эсвэл түүнд нийцэхгүйгээр тодорхойлсон үр дүн, төсөл, арга хэмжээ цөөнгүй хэвээр байна. Тухайлбал, тэргүүлэх чиглэлийн 3.3 дахь “Хөрөнгийн зах зээл болон банк, санхүүгийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна” гэсэн зорилгын хүрээнд дэвшүүлсэн таван зорилтын агуулга 2026 оны төлөвлөгөөнд огт тусгаагдаагүй байна.

Түүнчлэн **бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд баримтлахаар тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг жилийн төлөвлөгөөнд өөрчилж оруулсан байна.** Тухайлбал, “Бүсчилсэн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох” гэж тэргүүлэх чиглэлийн 1.1-д тусгасан ч энэ хүрээнд хүрэх ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд стандартчилал, хэмжил зүй, мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх гэх мэт өөр зорилтуудыг оруулсан. Мөн 2.6-д “Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн тэргүүлэх чиглэлийн зорилтод хамаарах төсөл, арга хэмжээ нь ЖХТ-ний 1.7.2, 1.7.3-т бичигдсэн, 4.6.2-т “Гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах, сөрөн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн ч үүнтэй холбоотой үр дүн, төсөл, арга хэмжээ нь Хүний хөгжлийн бодлогын 3.17-д тусгагдсан зэрэг зорилго, зорилт, үр дүн, төсөл, арга хэмжээг хооронд нь уялдаагүйгээр хольж бичжээ. **Энэ нь жилийн төлөвлөгөөг нягт нямбай байдлаар боловсруулаагүй, салбар, яам, агентлагаас ирсэн саналыг хариуцах байгууллагаар нь шууд нэгтгэж гаргасныг харуулж байна.**

Дүгнэж үзвэл, **бодлогын тэргүүлэх чиглэл болон жилийн хөгжлийн төлөвлөгөөнд** дараах **дутагдалтай талууд** байна гэж үзлээ. Үүнд:

- **Санхүүжилтийн эх үүсвэр, төсвийн тодорхойгүй байдал:** Төсөв, эх үүсвэрийн нарийвчилсан тооцоо, хөрөнгө оруулалтын бүтцийг дутуу тусгасан.
- **Хэрэгжилтийн хяналт, үнэлгээний тогтолцооны нарийвчлал дутмаг:** Үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллагууд тодорхой заагдаагүй.
- **Хэт өөдрөг, ерөнхий зорилтууд дэвшүүлсэн:** Зарим зорилго, арга хэмжээ хэт ерөнхий, хэмжигдэхүйц шалгуургүй, нэг жилд хэрэгжиж чадах эсэх нь эргэлзээтэй.
- **Төсвийн сахилга, үр ашигт хангалттай анхаараагүй:** Зардал бууруулахад чиглэсэн төсвийн реформыг хэрэгжүүлэхээр тусгагдсан ч тоон шалгуур, гүйцэтгэлийн хяналт сул.
- **Олон бодлого давхардсан байж болзошгүй:** Зарим арга хэмжээ өмнөх баримт бичгүүдэд тусгагдсантай ижил боловч шинэ санаачилга, ялгарал нь тодорхой бус.

**ТАВ. БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮН БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН УЯЛДАА, НИЙЦЭЛ**

Шалгуур үзүүлэлтүүдийн суурь ба зорилтот түвшинг бүрэн тодорхойлоогүй. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 63 үр дүн, хөтөлбөрийн 81 үр дүнг хангахын тулд **300 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлэхээр төлөвлөн тэдгээрийг хэмжих **331 шалгуур үзүүлэлт** тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүрээр үр дүнгийн гэх **суурь 192** болон **зорилтот 322** (2026 онд хүрэх) үзүүлэлтийг тодорхойлжээ. Гэхдээ нийт шалгуур үзүүлэлтийн 42.0 хувь буюу 139 шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг төлөвлөгөөнд огт тусгаагүй байна. Зорилтот түвшний тухайд 9 шалгуур үзүүлэлтийн (2.7 хувь) хүрэх түвшинг тодорхойлоогүй нь батлан хамгаалах салбарын буюу төрийн нууцтай холбогдох төсөл, арга хэмжээ болон мега төслүүдтэй холбоотой юм.

Мега төслүүдийн шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот үр дүн, санхүүжих дүн, эх үүсвэрийг тодорхойлоогүй нь хэрэгжих эсэхийг эргэлзээтэй болгож байна. Засгийн газрын зүгээс “2026 онд нэн шаардлагатай салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн. Гэвч Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан томоохон төслүүд болох “1.1.1.9. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангах”, “3.3.1.1.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах”, “3.5.1.1.Алт цэвэршүүлэх үйлдвэр барих”, “3.5.1.3.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах”, “3.5.1.5.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах”, “4.15.1.2.Үндэсний хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг хангах” зэрэг төслийн хувьд “Арга хэмжээний хэрэгжилт”, “Ажлын гүйцэтгэл” гэх мэтээр заримд нь нэг шалгуур үзүүлэлт бичсэн ч зарим нь огт шалгуур үзүүлэлтгүй, суурь ба зорилтот үр дүнгийн үзүүлэлт, нийт болон 2026 онд санхүүжих дүн, эх үүсвэргүй байгаа нь эдгээр төсөл хэрэгжиж эхэлсэн эсэх, хэрэгжих, бүрэн хэрэгжих боломжтой эсэхийг эргэлзээтэй болгож байна. Ийнхүү хөгжлийн бодлогын зорилтот үр дүнг үнэлэхэд шаардагдах үндсэн мэдээлэл болох шалгуур, түүний суурь ба зорилтот түвшний үзүүлэлтийг бүрэн тусгаагүй, системчилсэн хэлбэрээр гаргаагүй байгаа нь **жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянаж, дүгнэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй** юм.

Үр дүнгийн үзүүлэлтүүд SMART байх шаардлагыг бүрэн хангааагүй, зарим шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг бэлтгэхдээ бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, бодлогын үндэслэлд нийцүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, үр дүнгийн суурь болон зорилтот түвшинг гаргахыг хичээсэн нь ахицтай алхам болжээ. Гэвч Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд SMART буюу хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байх шаардлагыг бүрэн хангааагүй, зарим шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, тухайлбал, “арга хэмжээний хэрэгжилт”, “барилгын ажлын гүйцэтгэл”, “төслийн хэрэгжилт” гэх мэтээр хэт ерөнхий тодорхойлсон, зарим үзүүлэлтийн суурь түвшин байхгүй хэрнээ зорилтот түвшин нь бүгд 100 хувь гэх мэт байгаа нь хөгжлийн бодлого, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжгүй болгож байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг зорилтот болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнтэй холбон тодорхойлсон боловч хөтөлбөрийн үр дүн болон төсөл, арга хэмжээний үзүүлэлттэй бүрэн уялдаагүй байна.

Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө нь УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 2026 оны үзүүлэлтүүдийг хангаж байхын сацуу “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлж, 2026 оны үр дүнд хүрэхэд чиглэсэн байх ёстой.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” (УИХ-ын тогтоолын төслийн 3-р хавсралт)-ийг ***Тэргүүлэх чиглэлийн 4 үр дүн*** (5 шалгуур үзүүлэлт), ***Төсвийн ерөнхийлөн захирагчийн 60 үр дүн*** (75 шалгуур үзүүлэлт), ***Хөтөлбөрийн 81 үр дүн*** (111 шалгуур үзүүлэлт), ***нийт 145 зорилтот үр дүнтэй, 191 шалгуур үзүүлэлттэй***гээр боловсруулжээ. Эдгээр шалгуур үзүүлэлтийн ***зорилтот түвшинг бүрэн тодорхойлж тусгасан бол суурь түвшингийн тухайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн 9.3 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн 14.6 хувь нь тодорхойгүй*** байна. Үүнээс гадна ***“Тэргүүлэх чиглэлийн үр дүн”*** гэж тодорхойлсон 5 шалгуур үзүүлэлтийн суурь, зорилтот түвшин нь 2026 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнг хангахын тулд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ***шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь болон зорилтот түвшний үзүүлэлттэй бүрэн уялдаагүй байна.*** Мөн эдгээр үзүүлэлт жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгааг анхаарах шаардлагатай.

ЗУРГАА. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ЭХ ҮҮСВЭР

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төслүүдийн хэрэгжих боломж санхүүжилтийн эх үүсвэрээс шууд хамааралтай. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 15.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 300 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4.1 их наяд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2.2 их наяд, төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгөөр 4.3 их наяд, гадаад, дотоод хөрөнгө оруулалтаар 4.5 их наяд, бусад эх үүсвэрээс 0.6 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцжээ.

Төслүүдийн санхүүжилтийг тодорхой зааж өгөхийн гол зорилго нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөөлөл дэх төсвийн зарлагыг бодитой болгох явдал юм. Ийм учраас авто болон төмөр зам, эрчим хүч, аж үйлдвэрийн парк зэрэг зардал ихтэй стратегийн төслүүдийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг сайтар тооцож, санхүүжилтийн эх үүсвэр, төсвийг илүү тодорхой болгох хэрэгтэй.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийт 300 төсөл, арга хэмжээг тусгаж, санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 4. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байдал

№	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүүжилтийн нийт дүн, сая төгрөг	Нийт санхүү - жилтэд эзлэх хувь	Тухайн жилд шаардагдах санхүүжилт, сая төгрөг	Тухайн жилийн санхүүжилтэд эзлэх хувь	Санхүүжилтийн дүн нь тодорхойгүй төсөл
1	Улсын төсөв	204	8,955,010.2	13.0%	2,776,995.0	17.6%	14
2	Гадаадын зээл	25	11,122,286.0	16.1%	2,141,436.7	13.6%	1
3	Орон нутгийн төсөв	10	4,879,346.3	7.1%	1,307,597.2	8.3%	
4	Дотоодын хөрөнгө оруулалт	8	5,240,014.9	7.6%	1,925,691.4	12.2%	
5	Гадаадын тусламж	6	345,586.5	0.5%	108,523.3	0.7%	
6	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ	9	25,686,440.1	37.2%	4,277,586.1	27.2%	
7	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	4	6,356,265.4	9.2%	1,651,513.5	10.5%	
8	Гадаадын хөрөнгө оруулалт	3	4,002,466.7	5.8%	901,580.8	5.7%	
9	Улсын төсөв, Гадаадын зээл	3	787,446.0	1.1%	189,000.9	1.2%	
10	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэр	2	-		-		2
11	Бусад эх үүсвэр	1	-		-		1
12	Гадаадын зээл, тусламж	1	-		-		1
13	Гадаадын зээл, Төр хувийн хэвшлийн түншлэл	1	1,052,033.6	1.5%	210,406.7	1.3%	
14	Гадаадын зээл, Улсын төсөв	1	358,000.0	0.5%	179,000.0	1.1%	
15	Улсын болон орон нутгийн төсөв	1	15,000.0	0.0%	15,000.0	0.1%	
16	Улсын болон орон нутгийн төсөв, Гадаадын зээл	1	72,000.0	0.1%	51,000.0	0.3%	
17	Улсын төсөв, гадаадын тусламж	1	14,200.0	0.0%	9,000.0	0.1%	
18	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төслүүд	19	134,170.0	0.2%	-		19
НИЙТ		300	69,020,265.7	100%	15,744,331.6	100.0%	38

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Нийт санхүүжилтийн эх үүсвэрийн 20.1 хувийг төсөв¹, үлдсэн хэсгийг бусад 15 төрлийн санхүүжилтийн эх үүсвэр эзэлж байна.

“Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т богино хугацааны буюу нэг жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн талаар “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэж заажээ. Энэхүү заалтыг хэрэгжүүлсэн байдал болон санхүүжилтийн ерөнхий нөхцөл зэргийг харгалзан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтыг *Засгийн газрын* зүгээс **8.1 их наяд төгрөг**,

¹ Төсвийн хөрөнгө оруулалтын дүнд а) Улсын төсөв, б) Орон нутгийн төсөв, в) Улсын төсөв, орон нутгийн төсөв гэсэн гурван хэсгийн дүнг хамруулсан болно.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс макро эдийн засаг, төсвийн гол үзүүлэлтүүдийн таамаглалд **9.3 их наяд төгрөг** байхаар төгрөгөөр тусгасан. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүн 15.7 их наяд төгрөг байхаар тусгасан нь нийт төсвийн зардлын 46.9 хувийг эзэлж байна.

2. *Нийт санхүүжилтийн дүн тодорхойгүй 38 төсөл, арга хэмжээ байгаа* бөгөөд үүний дотор мега төслүүдийн хэмжээнд тооцогдож байгаа зарим төслүүд орсон байна. Тухайлбал, Байгалийн хийн хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангах, Экспортыг төрөлжүүлэх, Нэмүү өртөг шингэсэн бүтээгдхүүний үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бүс нутгийн эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн экспортын чөлөөт бүсийг Хархорум хотод байгуулах зэрэг төслүүд байна.
3. *Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй нийт 134.2 тэрбум төгрөгийн зардалтай 19 төсөл, арга хэмжээ байна.* Үүнд 126.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Байдрагийн усан цахилгаан станц, 7.6 тэрбум төгрөгийн Хэрлэн-Тооно усан цогцолборын төсөл гэх мэт төсөл, арга хэмжээнүүд багтаж байна.
4. *Хоёр буюу түүнээс дээш эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ 2,304.9 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 14.6 хувийг эзэлж байна.* Жилийн хөгжлийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй танилцуулгад тухайн төсөл, арга хэмжээнд аль эх үүсвэрийг хэдий хэмжээгээр дайчлан татах талаар тодорхой тоон мэдээллийг тусгаагүй байна.
5. *Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийт 9 төслийг 25.7 их наяд төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь нийт санхүүжилтийн 37.2 хувийг эзэлж байна.* Хуульд зааснаар аливаа төсөл, арга хэмжээ хариуцах эзэнтэй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл нь батлагдсан байх шаардлагатай бөгөөд хариуцах төрийн байгууллагыг заасан боловч бусад мэдээллүүдийг тодорхой тусгаагүй байна.
6. *Гадаадын зээл, тусламжаар Дархан-уул аймагт орон нутгийн лавлагаа шатлалын эмнэлэг барихаар нэг төслийг тусгасан.* Гэвч төслийн нийт санхүүжилтийн дүн болон гадаадын ямар зээл, тусламжаар барих талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
7. *Цэвэр гадаадын зээлээр 25 төслийг нийтдээ 11,122.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.* Эдгээр төсөл, арга хэмжээний дотор дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бүрэн хийж гүйцэтгэх боломжтой төслүүд байна. Тухайлбал, Улаанбаатар хотод Солонго-I, II орон сууцны хорооллын төслийг Өмнөд Солонгос улсын Эксим банкны 857.0 тэрбум төгрөгийн дүнтэй тэнцэхүйц гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Иймд цаашид цэвэр гадаадын зээлээр санхүүжих төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг хийхдээ хөрөнгө оруулалтын үр өгөөж, зориулалт гэх мэт шалгуурыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.
8. Үндэсний Аудитын Газраас Монгол Улсын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайландаа “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний *хэрэгжилт 52.1 хувьтай, богино хугацааны баримт бичгийг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан байх зарчмыг хангаагүй, олон нийт санал өгөх боломжийг бүрдүүлээгүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоогүй 43, ТЭЗҮ, зураг төсөвгүй 26 төсөл, арга хэмжээг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна*” гэж дүгнэсэн.
9. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл арга хэмжээний жагсаалтад өмнөх 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд УАГ-аас хийсэн аудитын тайлангийн

дүгнэлтэд тусгагдсантай адил зөрчилтэй, тухайлбал, *санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоогүй төсөл, арга хэмжээнүүд орсон нь төлөвлөгөөний хэрэгжилт маш доогуур байхад ихээхэн нөлөө үзүүлж байна.*

ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН МЕГА ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд тусгагдсан 14 мега төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг жишээ болгон авч үзвэл:

1. Хөтөлбөрт Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж заасан бөгөөд 2025, 2026 оны төлөвлөгөөнд яг адил агуулгаар томьёологдож, УИХ-аас энэ оны 3 дугаар сард Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээрийг соёрхон баталснаар бүтээн байгуулалтын ажил эхлэх боломж бүрдсэн. Харин Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд *Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр зам болон ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих, “Шивээхүрэн-Сэхээ” хил холболтын төмөр зам барих гэж тусгасан ч 2026 оны төлөвлөгөөнд энэ талаар огт дурдаагүй* байна.
2. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барих төслийн хувьд 2025 оны төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэргүйгээр “Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийх”, 2026 оны төлөвлөгөөнд *гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 689 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж тусгасан ч уг төслийн нийт өртөг 2.3 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн юм.*
3. 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт анх тусгагдсанаас хойш жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөний зорилт болж ирсэн 776.4 тэрбум төгрөгийн өртөгтэй Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төсөлд улсын төсөв, гадаадын зээлээр 2025 онд 100 тэрбум, 2026 онд 178 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон нь мөн л *эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй.*
4. Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барих төсөлд 2025 онд 2 тэрбум, 2026 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасан байх бөгөөд Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох, “Байгал нуур”-т үзүүлэх олон талт нөлөөллийн судалгааг дэлхийн өвийн хорооны аргачлалд нийцүүлэн боловсруулах, ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хороогоор *шийдвэр гаргуулах олон ажил шил дараалан хүлээгдэж байна.*
5. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх төслийн хувьд *2025 оны төлөвлөгөөний “Хөтөлбөрийн үр дүн” гэсэн хэсэгт “Сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ” гэж заасан ч 2026 оны төлөвлөгөөнд энэ талаар нэг ч үг, өгүүлбэр байхгүй* юм. Гэтэл энэ зорилт 2025 ондоо хэрэгжээд дууссан талаар ямар нэг тайлан байхгүй байна.
6. Говийн бүсийг усаар хангахад нэн чухал ач холбогдолтой “Орхон-Онги”, “Хэрлэн-Тооно” ус дамжуулах хоолойг барих төслийн тухайд 2025, 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд яг адилхан “Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслийн бэлэн байдлыг хангах” заалт тусгаж, 2025 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр 17.9 тэрбум, 2026 онд улсын төсвөөс 13.5

- тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөж, Орхон-Онги төслийн эхний шатны “Цагаан бургастай-Онгийн усан цогцолбор”-ыг байгуулж, Улаан нуурын экосистемийг сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Харин “Хэрлэн-Тооно” төслийг хэрэгжүүлэхэд учрах гол *саад бэрхшээл бол одоогоор нарийн тооцож гаргаагүй их өндөр зардал, геополитикийн асуудалтай холбоотой үүсэх эрсдэл* юм.
7. Эрэнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барих төслийн талаар *2025, 2026 оны төлөвлөгөөнд огт дурдаагүй* байна.
 8. Монгол, Францын хамтарсан Ураны төслийн хувьд 2025 онд санхүүжилтийн ямар нэг эх үүсвэргүйгээр бэлтгэл ажлыг эхлүүлэх гэж дурдсан, 2025 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар БНФУ-ын “Орано Майнинг” энгийн хувьцаат компанитай хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж, *2026 оны жилийн төлөвлөгөөнд* гадаадын хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ураны ордыг ашиглах гэрээний хэрэгжилтийг хангахад гадаадын хөрөнгө оруулалтаар *779.6 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон* байна.
 9. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор байгуулах төслийн тухайд 2025, 2026 оны жилийн төлөвлөгөөнд “Тавантолгой үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн адилхан зорилт тусгаж, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 2025 онд 742.7, 2026 онд 460.7 тэрбум төгрөг төсөвлөсөн ч 2026 оны төлөвлөгөөнд заасан “Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах” *төсөлд ямар нэг санхүүжилтийн эх үүсвэр тусгаагүй байна.*
 10. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн барилгын ажлын гүйцэтгэлд зориулан *2025 онд 804.7, 2026 онд 501.7 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасан ч нийт өртөг 2.5 их наяд төгрөг учраас энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжихээргүй* харагдаж байна.
 11. Гангийн цогцолбор байгуулах төслийн тухайд 2026 оны жилийн төлөвлөгөөнд “Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах” гэж бичсэн ч *санхүүжилт огт хуваарилаагүй төдийгүй шалгуур үзүүлэлт, үр дүнгийн үзүүлэлт ч байхгүй хоосон* мөр байна.
 12. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг гол зорилт болох *Газрын тос боловсруулах цогцолбор байгуулах ажил 2016 онд эхэлсэн бөгөөд 2028 онд төслийг дуусгахаар төлөвлөж байна.* Гадаад зээлээр бүрэн санхүүжих энэ төслийн нийт өртөг 4.178,8 тэрбум төгрөг юм. 2016-2025 онд 620.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 2026 оны төлөвлөгөөнд гадаадын зээлээр 894.2 тэрбумын санхүүжилт татахаар төлөвлөсөн. Ийм байдлаар цаашид явна гэвэл *төлөвлөсөн хугацаандаа дуусах боломжгүйгээс гадна энэ төслийн хувьд тодорхойгүй маш олон асуудал хүлээгдэж байгаа* юм.
 13. *Алт цэвэршүүлэх үйлдвэрийг 276.8 тэрбум төгрөгөөр дотоодын хөрөнгө оруулалтаар барих зорилт тавьсан боловч 2026 онд ердөө 1 тэрбум төгрөг төлөвлөжээ.* Энэ төсөл 1998 оноос хойш яригдаж, үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт болсоор 2021 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан ч одоо ч *эхлэлийн төдий байгаа* билээ. Түүнээс гадна төслийн хүчин чадлыг жилд 75 тн алт цэвэршүүлэхээр тооцсон нь Монголбанк ганц удаа л 22 тн алт худалдан авч байсантай харьцуулбал судалгаанд үндэслэсэн төсөл гэж үзэх боломжгүй юм.
 14. 2025 оны төлөвлөгөөнд “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх” гэж заасан ч 2026 оны төлөвлөгөөнд энэ төслийн бэлтгэл ажлыг хангана гэж ямар ч үр дүнгийн шалгуур үзүүлэлтгүй оруулжээ. Энэ нь аливаа бодлого, зорилт

судалгаа тооцоотой байх, шинжлэх ухааны үндэслэлтэй байх, эдийн засгийн хувьд үр ашигтай байх шалгуурыг хангаагүй гэж үзэхэд хүргэж байна.

Ийнхүү хөгжлийн бодлого төлөвлөлт уялдаагүй, залгамж холбоогүй, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байдлын улмаас төлөвлөсөн зорилтын ихэнх нь хугацаандаа хэрэгжих боломжгүй нь харагдаж байна. Түүнээс гадна өндөр өртөгтэй, хэрэгжих үндэслэл багатай, эдийн засгийн үр ашиг нь тодорхойгүй Арцсуурь-Шивээхүрэн чиглэлийн баруун босоо 1,255 км төмөр зам, Ханх-Хатгал авто зам зэрэг төслийг дурдаж болно. Энэ бүх баримт улс орны хөгжлийн бодлогыг нэгтгэн зангидах бодлого, төлөвлөлтийн чадавх сул байгааг харуулж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний тодорхойлолт, 9 дүгээр зүйлийн 9.2.6-д УИХ “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлах” гэж заасан. Тийм учраас ***Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулахаас өмнө “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Улсын хөрөнгө оруулалтын 2026-2030 оны хөтөлбөр”-ийг УИХ-аар батлуулах учиртай*** юм.

УИХ-аас батлан гаргасан хөгжлийн бодлогын баримт бичгүүд, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэрийн тооцоолол хийгдсэн байх ёстой. Гэвч өнөөгийн байдлаар УИХ-аар батлан Засгийн газарт өгсөн зарим үүрэг, даалгавар хэрэгжээгүй байна.

- УИХ-аас 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцэн баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан УИХ-ын 21 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтад: ***“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолж, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх”***-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгажээ. Гэвч УИХ-ын энэхүү тогтоол батлагдан гарснаас хойш 8 сарын хугацаа өнгөрч байгаа боловч одоогоор ийм өртөг зардлын, эх үүсвэрийн тооцоолол хийгдсэн эсэх талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
- УИХ-ын 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы хуралдаанаар “Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай” хуулийг хэлэлцэн баталсан. Уг хуулийн 24 дүгээр зүйлд “Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсвөөс болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх”-ээр заасан. Уг хуулийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэ оноос эхлэн Хархорум хотын бүтээн байгуулалттай холбогдсон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсвийг жил бүрийн улсын төсөвт тусгах шаардлагатай болно.
- ЗГҮАХ-ийг баталснаас хойш 4 сарын дараа 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-ын чуулганы хуралдаанаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолыг хэлэлцэж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ирэх 25 жилд нийтдээ 236.2 их наяд төгрөг, үүний дотор улс, орон нутгийн төсвөөс 94.8 их наяд төгрөгийг зарцуулах шаардлагатай гэсэн тойм тооцоо хийсэн байна. УИХ-ын хаврын чуулганаар дээрх тогтоолыг хэлэлцэн төслөөр нь баталсан тохиолдолд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг

хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улс, орон нутгийн төсөвт тусгах шаардлага мөн үүснэ. Энэхүү ерөнхий төлөвлөгөөг 15 жилд хэрэгжүүлнэ гэж тооцвол улсын төсөвт жил бүр 6 их наяд төгрөгийн дарамт ирэхээр байгаа бөгөөд төсөв үүнийг даах боломжгүй юм.

Эдгээрээс үзвэл, ирэх 2026-2028 онд Засгийн газар, нийслэл, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүд, нийт зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухам хэдий хэмжээний хөрөнгө, эх үүсвэр шаардлагатай талаарх тооцоо өнөөг хүртэл тодорхой болоогүй байгаа юм. Иймээс УИХ-ын дээрх тогтоолуудаар Засгийн газарт өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэрийн тооцоог хийсэн байх шаардлагатай гэж үзэж байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ТТБЗ-өөс Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж, холбогдох зөвлөмжийг хүргүүлж байна.

Дүгнэлт

1. **Бодлогын уялдаа, стратегийн нийцэл үндсэндээ хангагдсан боловч хэрэгжилтийн түвшинд доголдолтой байна.** Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө нь урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа–2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй зорилгын түвшинд уялдсан боловч дэд зорилт, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн уялдаа бүрэн бус, зарим зорилт хоорондоо давхардсан, эсвэл хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь хоорондоо нийцэхгүй байна.
2. **Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул, шалгуур үзүүлэлтүүд SMART байх шаардлага хангагдаагүй байна.** Жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 331 шалгуур үзүүлэлтийн 42 хувь нь суурь түвшингүй, зарим үзүүлэлтүүд зорилтот түвшингүй, хэт ерөнхий, хэмжих боломжгүй байдлаар тодорхойлогдсон нь хяналт-шинжилгээ, үнэлгээний бодит боломжийг алдагдуулж байна.
3. **Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн тооцоо бүрэн хийгдээгүй байна.** Төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл, арга хэмжээний 19 нь санхүүжилтийн эх үүсвэргүй, олон төслийн хувьд эх үүсвэрийн бүтэц тодорхой бус, хэт өөдрөг төсөөлөлд тулгуурласан нь хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мөн мега төслүүдийн хувьд төслийн нийт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөж тодорхой бус, зарим нь олон жил дараалан жилийн хөгжлийн төлөвлөгөөнд багтсан боловч хэрэгжилтийн бодит ахиц харагдахгүй байна.
4. **Төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын үр ашигт хангалттай анхаарал хандуулах шаардлагатай байна.** Томоохон төсөл, хөтөлбөрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөв, хариуцах эзэн, байгууллага тодорхой бус, хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөжийн тооцоолол хангалтгүй байна. Энэ нь төсвийн хуваарилалт оновчгүй байх, хэрэгжилт зогсонги байдалд орох эрсдэлийг дагуулна.
5. **УИХ-аар баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт хангалтгүй, эрх зүйн зохицуулалтын дараалал, уялдаа алдагдсан байна.** Хуульд заасны дагуу

“Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “2026–2030 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдийг УИХ-аар баталсны үндсэн дээр жилийн төлөвлөгөөг боловсруулах учиртай ч уг шаардлагыг бүрэн хангаагүй байна. УИХ-аас Засгийн газарт даалгасан өртөг зардлын тооцоо хийх, өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийсэн эсэх талаарх мэдээлэл байхгүй байна.

Зөвлөмж

1. ***Жилийн хөгжлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг SMART зарчимд нийцүүлэн илүү боловсронгуй болгон сайжруулах.*** Зорилгуудыг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжих боломжтой, бодитой, хугацаатай байдлаар тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүрд суурь болон зорилтот түвшинг заавал тусгах, хэт ерөнхий, чанарын шинжтэй үзүүлэлтүүдийг нарийвчлах шаардлагатай (Хавсралт 3).
2. ***Хөрөнгө оруулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн тодорхой болгох.*** Санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын тооцооллыг ил тод, бодитой болгож, эдийн засгийн үр өгөөжгүй, хэт өндөр өртөгтэй, эрсдэлтэй төслүүдийг дахин нягталж, эрэмбэлж хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн ТХХТ-ийн төсөлд тавих шалгуурыг нарийвчлан тодорхойлох нь чухал.
3. ***Төлөвлөлт ба төсөвлөлтийн уялдааг сайжруулж, Төсвийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангахад анхаарах.*** Жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрийн санхүүжилтийн дүн, эх үүсвэр, зарцуулалт, хэрэгжилтийн хугацаа зэрэг мэдээллийг Төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан нарийн тусгаж, төсвийн сахилга батыг сайжруулах, өрийн тогтвортой байдлыг хадгалахад илүү анхаарах шаардлагатай.
4. ***Мега төслүүдийн хэрэгжих бодит боломж, шалгуур үзүүлэлтийг үнэлж, хэрэгжилтийн стратегийг тодорхойлох.*** Төсвийн хувьд онцгой ач холбогдолтой гэж үзэж буй мега төслүүдийн шалгуур үзүүлэлт, санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл, үр өгөөжийг нарийвчлан үнэлж, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх стратегийг боловсруулж, огт судалгаагүй, ач холбогдол нь тодорхой бус төслүүдийг төлөвлөгөөнөөс хасах саналыг дэвшүүлж байна.
5. ***УИХ-аас Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн өмнөх тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг эргэн хянан, тайлагнах механизмыг бий болгох.*** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, эх үүсвэрийн үнэлгээ, өрийн ачаалал зэрэг асуудлаар УИХ-ын тогтоолоор өгсөн чиглэлүүдийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, тухайн баримт бичгүүдийн хэрэгжилт, нийцлийг үнэлэх талаар холбогдох төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай.
6. ***Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн зардал, үр ашгийн тооцоо, шинжилгээг төсөл бүр дээр хийж гүйцэтгэн жилийн төсвийн төсөлтэй хамт УИХ-д өргөн мэдүүлж байх*** нь зүйтэй гэж үзэж байна.

**ХАВСРАЛТ 1. БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ҮР ДҮНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ**

Бодлогын тэргүүлэх чиглэл			Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө						Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний ХШҮ-ний үзүүлэлт							
Тэргүүлэх чиглэл	Бодлогын зорилго	Зорилтууд	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	ҮД-ийн үзүүлэлт		Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн				Хөтөлбөрийн үр дүн			
							Суурь түвшин	Зорилтот түвшин	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин
1. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1.1	4	1.2-1.5	4	6	8	2	8	4	4	4	4	4	6	4	6
	1.2	4	1.1, 1.6, 1.7.1, 1.8-1.11	11	65	71	41	70	7	10	9	10	9	15	14	15
	Нийт	8	11	15	71	79	43	78	11	14	13	14	13	21	18	21
2. Хүний хөгжлийн бодлого	2.1	13	2.2-2.7	6	22	31	22	31	6	7	7	7	6	15	15	15
	2.2	6	2.1, 2.8	4	10	10	7	10	2	4	4	4	5	6	6	6
	2.3	6	2.9-2.11, 2.14, 2.15	5	11	11	7	11	5	5	5	5	5	5	5	5
	2.4	3	2.13	2	3	3	2	3	1	1	1	1	2	3	3	3
	2.5	4	2.12	1	2	2	2	2	1	1	1	1	1	1	0	1
	2.6	3	1.7.2, 1.7.3	2	6	6	4	6	1	1	1	1	3	4	2	4
	Нийт	35	17	20	54	63	44	63	16	19	19	19	22	34	31	34
3. Эдийн засгийн бодлого	3.1	10	3.14, 3.15	2	15	15	7	15	1	1	1	1	1	3	3	3
	3.2	5	3.3, 3.15	2	7	7	5	6	2	2	2	2	2	2	2	2
	3.3	5	Байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	3.4	9	3.1, 3.2, 3.4, 3.6, 3.7, 3.16, 3.18	9	47	49	26	45	7	12	10	12	11	18	17	18
	3.5	5	3.5	2	18	16	11	16	1	1	1	1	2	2	2	2
	3.6	4	3.10, 3.11, 3.12, 3.13	5	15	20	15	20	4	4	4	4	5	6	6	6
		2	3.8 (Соёл), 3.9 (АЖ)	2	3	4	4	4	2	4	3	4	2	2	2	2
	Нийт	40	18	22	105	111	68	106	17	24	21	24	23	33	32	33

4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	4.1	4	4.3, 4.4, 4.5, 4.6, 4.11, 4.16	8	12	14	6	14	6	6	6	6	8	8	3	8
	4.2	5	4.7, 4.9	6	24	27	11	27	2	2	2	2	6	6	6	6
	4.3	4	4.2	1	15	16	7	13	0	0	0	0	1	1	0	1
	4.4	3	4.1	1	2	2	1	2	1	1	1	1	1	1	1	1
	4.5	5	4.8, 4.10, 4.12, 4.13, 4.14, 4.15	7	14	15	10	15	6	6	5	6	6	6	3	6
	4.6	2	3.17	1	3	4	2	4	1	1	1	1	1	1	1	1
	Нийт	23	17	24	70	78	37	75	16	16	15	16	23	23	14	23
НИЙТ	20	106	63	81	300	331	192	322	60	73	68	73	81	111	95	111

ХАВСРАЛТ 2. БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, 2026 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН УЯЛДАА, НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭ

ЖХТ-ний хавсралтууд хоорондын уялдаа, нийцэл

Хавсралтууд	Уялдаа, нийцлийн түвшин	Тайлбар
01 ↔ 02: Бодлогын тэргүүлэх чиглэл ба ЖХТ-ний уялдаа	✓ Сайн	Стратеги болон тактикийн түвшинд бодлого, үйл ажиллагаа харьцангуй сайн уялдсан.
02 ↔ 03: ЖХТ ба ХШҮ-ний үзүүлэлт хоорондын уялдаа	⚠ Дунд	Зарим салбарт хөрөнгө оруулалтын нарийвчлал багатай, гэхдээ ерөнхий төлөвлөлт нийцтэй. Санхүүжилтийн чиглэлүүд стратегийн зорилтуудтай уялдсан ч зарим реформын төсөв тодорхой бус.
01 ↔ 03: Бодлогын тэргүүлэх чиглэл ба ХШҮ-ний үзүүлэлтийн уялдаа, нийцэл	⚠ Дунд	Бодлогын зорилтот үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд байгаа ч зарим нь ерөнхий, мөн тодорхой үр нөлөөг илэрхийлэхэд хангалтгүй.

Нийцлийн дүн шинжилгээ

Үзүүлэлт	Нийцэл/Уялдаа	Тайлбар
Бодлогын тэргүүлэх чиглэл ↔ Зорилтот үр дүн	✓ Сайн	Бодлогын тэргүүлэх 4 чиглэлийн хүрээнд тодорхой зорилтууд (Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, ЭЗ-ийн эрх чөлөө, Шударга засаглал) нь ЖХТ-нд тусгагдсан.
Бодлогын зорилтууд ↔ Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	✓ Дунд/Сайн	Ихэнх хөтөлбөр, төсөл (жишээ нь “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “10,000 нарны дээвэр”, “Миний түрээсийн орон сууц”) бодлогын чиглэлтэй логикоор уялдсан. Гэхдээ зарим төсөл, үйл ажиллагаа нь бодлогын зорилтот түвшинтэй тоон болон чанарын хувьд бүрэн холбогдоогүй .
Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэлийн үр дүн ↔ Шалгуур үзүүлэлтүүд	⚠ Дунд	Хариуцагч байгууллагууд (Ерөнхийлөгчийн Тамгын газар, яамд, агентлагууд)-ыг тодорхой заасан. Гэвч зарим шалгуур үзүүлэлт ерөнхий, тоон бус, хэмжих боломжгүй (тухайлбал, “чанарыг сайжруулна”, “Тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлнэ” гэх мэт).
Суурь түвшин ↔ Хүрэх түвшин ↔ Санхүүжилт	⚠ Дунд/Хязгаарлагдмал	Зарим шалгуурт суурь түвшин заасан ч ихэнхдээ нарийн тооцоолсон суурь ба зорилтот түвшин байхгүй. Санхүүжилтийн хэмжээг тусгасан ч тухайн төсөл/арга хэмжээнд харгалзах үр дүнгийн шууд хамаарал тодорхой бус байна.

Ерөнхий дүгнэлт: Уялдаа ба санал

Шалгуур	Үнэлгээ	Тайлбар
Бодлого – Төсөл – Төсөв уялдаа	✓ Сайн	ЖХТ нь бодлогын зорилт бүрд санхүүжилт, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллагыг холбосон.
Үр дүнгийн хэмжигдэхүйц байдал	⚠ Дунд	ХШҮ-ний үзүүлэлтийн хэмжүүрүүд байгаа ч зарим нь ерөнхий, мөн тодорхой үр нөлөөг илэрхийлэхэд хангалтгүй.
Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн тодорхой байдал	⚠ Хэсэгчлэн	Зарим төсөлд эх үүсвэр тодорхойгүй, “-” гэсэн тэмдэглэгээтэй.
Хариуцах байгууллагын хуваарилалт	✓ Сайн	Үндсэн хариуцагч тодорхой, гэхдээ уялдаа, давхардлыг цаашид нарийвчлах шаардлагатай.
Мэдээлэл цуглуулалт, мониторинг	⚠ Дунд	Судалгааны арга зүй, эх сурвалж заасан ч тогтолцоо, хяналт, гүйцэтгэлийн тайлагнал тодорхойгүй.

Төлөвлөгөө ба төсвийн уялдаатай холбогдох ТОДОРХОЙ ЖИШЭЭ

Бодлогын чиглэл	Хөтөлбөр/төсөл	Санхүүжилт (Хавсралт 3)	Уялдаа
Хүний хөгжил	108 сургууль, 95 цэцэрлэг	✓ Хамрагдсан (~1.2 их наяд)	✓
	Түрээсийн орон сууц	✓ (~2.5 их наяд)	⚠ Нэгж өртөг, зорилтот бүлэг тодорхойгүй
Эдийн засгийн төрөлжилт	Хүнсний хувьсгал, Атар 4, Цагаан алт	✓ (~600 тэрбум орчим)	✓
Дэд бүтэц, эрчим хүч	Эдийн засгийн коридор, сэргээгдэх эрчим хүч	✓ (их хэмжээтэй)	✓
Шударга засаглал, цахим засаг	Хиймэл оюунд суурилсан төрийн үйлчилгээ	✗ Тусгайлан заасан төсөвгүй	✗

Жилийн хөгжлийн төлөвлөгөөний дотоод уялдаа

Дэд чиглэл	Төслийн нэр / Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь / Хүрэх түвшин
Боловсрол	“Хамгийн сайн сургууль - гэрт ойр” хөтөлбөр	Шинээр ашиглалтад орсон сургуулийн тоо	Суурь: 0 / Хүрэх: 108 сургууль
	Цэцэрлэг барих	Баригдсан цэцэрлэгийн тоо	Суурь: 0 / Хүрэх: 95
	Багшийн 3 тулгуурт бодлого	Сургалтад хамрагдсан багшийн хувь	Тодорхойгүй
Эрүүл мэнд	Орон нутгийн эмнэлгийн шинэчлэл	Тоног төхөөрөмжийг нь шинэчилсэн эмнэлгийн тоо	Суурь байхгүй, тоо тодорхойгүй
	“Их өгөгдөл ашиглах”	Мэдээллийн системд холбогдсон ЭМ-ийн байгууллагын хувь	Тодорхойгүй
Нийгмийн халамж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төвүүд	Төвүүдийн тоо / хүртээмж	Суурь: 0 / Хүрэх: 21 (аймаг бүрд)
Орон сууц	“Миний түрээсийн орон сууц”	Түрээсийн орон сууцны тоо	Суурь: тодорхойгүй / Хүрэх: 150,000

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ SMART ЗАРЧИМД НИЙЦҮҮЛЭН
БОЛОВСРУУЛСАН ЖИШИГ ЖАГСААЛТ**

№	Үзүүлэлт	SMART хувилбар	Тайлбар
1	“Шинээр барих сургууль”	2026 онд улсын хэмжээнд 108 шинэ сургууль ашиглалтад оруулж, 1 ангид ногдох сурагчийн тоог 40-аас 35 болгон бууруулна.	Specific, Measurable, Achievable, Relevant, Time-bound
2	“Цэцэрлэгийн хүртээмж”	2026 онд 95 шинэ цэцэрлэг ашиглалтад оруулж, 3-5 настай хүүхдийн хамран сургалтыг 78%-аас 90% хүртэл нэмэгдүүлнэ.	Суурь түвшин бүхий, хэмжигдэхүйц, хүрэхүйц
3	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ”	2026 онд 21 аймаг тус бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цогц үйлчилгээний төв байгуулна (гэхдээ зарим аймагт өмнө байгуулагдсан бол энэ тоог багасгах).	Тодорхой, хугацаатай
4	“Орон нутгийн эмнэлгийн шинэчлэл”	2026 онд 21 аймгийн нэгдсэн эмнэлэг бүрийг MRI төхөөрөмжөөр тоноглож, хоёрдогч шатлалын оношилгооны боломжийг 100% болгоно.	Measurable, Achievable
5	“Орон сууцны хүртээмж”	2026 онд нийт 150,000 айлын орон сууцны 70%-ийг өрхийн сарын орлого ≤ 2 сая төгрөгтэй бүлэгт зориулна.	Хүлээгдэж буй үр дүнгийн хүртээмжийг тодорхойлсон
6	“Багшийн мэргэжлийн хөгжил”	2026 онд төрийн өмчийн бүх ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй багш нарын 90%-ийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.	Тоон зорилттой, уялдаатай
7	“Нийгмийн даатгалын хамрах хүрээ”	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил эрхлэгчдийн эзлэх хувь 2024 онд 65% байсныг 2026 онд 75% болгон нэмэгдүүлнэ.	Суурь ба зорилтот түвшинтэй, хэмжигдэхүйц
8	“Хүүхдийн хамгаалал”	2026 онд хүүхэд хамгааллын кейс менежментийн тогтолцоонд бүртгэгдсэн хэрэгт 90%-ийн хариу арга хэмжээ авч, 60%-ийг 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.	Чанарын дүн шинжилгээ хийх боломжтой SMART хэлбэр
9	“Цахим боловсрол”	2026 онд 100% их, дээд сургуулиуд нэгдсэн цахим хичээлийн платформ ашиглаж, бакалаврын түвшинд 30%-ийн кредитийг цахимаар эзэмших боломжтой болно.	Шинэлэг, бодит SMART хэлбэр
10	“Эрүүл мэндийн дата систем”	2026 он гэхэд улсын хэмжээнд эрүүл мэндийн 100% байгууллага “Их өгөгдөл” платформд холбогдсон байна.	Хэмжигдэхүйц, шалгаж батлах боломжтой үзүүлэлт